


МАЛ ТООЛЛОГЫН ДҮН ГАРЛАА

Манай аймаг 2015 онд 379.5 мянган толгой малтай болсон нь өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өслөө. Үүнд адуу 18.1 мянган толгой буюу 20.6 хувиар, үхэр 12.4 мянган толгой буюу 19.2 хувиар, хонь 169.1 мянган толгой буюу 11.3 хувиар, ямаа 179.0 мянган толгой буюу 11.8 хувиар өсч, тэмээ 869 толгой буюу 0.3 хувиар буурсан байна.



	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
Баянтал сум	138	3 639	1 930	26 200	25 467	57 374
Сүмбэр сум	639	12 990	8 879	123 602	132 283	278 393
Шивээговь сум	92	1 520	1 581	19 288	21 229	43 710
Нийт	869	18 149	12 390	169 090	178 979	379 477

Сумдын малын тоог өмнөх оны мөн үетэй хаьцуулбал Сүмбэр сум 11.9 хувиар, Баянтал сум 7.2 хувиар, Шивээговь сум 6.4 хувиар малаа өсгөсөн үзүүлэлт гарлаа.

Нийт малчдын тоо 1160 болж өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар, малчин өрх 673 болж өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд 1000 ба түүнээс дээш толгой малтай өрх 92 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар өслөө.